

## Кино урлагийг дэмжих сангийн 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны А/61 дугаартай “Хувь хэмжээний тушаал”-ын хэрэгжилтийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангаас 2024 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг 2022.10.02 – 2022.11.03-ний өдрийн хооронд төсөл, арга хэмжээний мэдүүлгийг системээр хүлээн авсан бөгөөд нийт 45 төсөл бүртгэгдсэн байна.

“Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкийг сонгон шалгаруулах, хөнгөлөлтэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих” журмын 5.1-д Зөвлөл санхүүжилт хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш 45 хоногт багтаан хуралдаж хүсэлтийг хэлэлцэн төсөл, арга хэмжээг үнэлэн сонгон шалгаруулж, санал, дүгнэлт гаргаж соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ гэж заасны дагуу сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий зөвлөл 10 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, сонгон шалгаруулалтыг гүйцэтгэн нийт 10 төсөл, арга хэмжээг дэмжихээр зөвлөлийн гишүүдийн дүгнэлт бүхий Зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн №44 тогтоол, холбогдох хурлын тэмдэглэлийг Соёлын сайдад хүргүүлсэн.

2024 онд шалгарсан нийт 10 төсөл, арга хэмжээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Зардал батлах тухай” А/183 дугаар тушаалаар Кино урлагийг дэмжих сангаас эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилтийн 1,012,683,150 (*нэг тэрбум арван хоёр сая зургаан зуун наян гурван мянга нэг зуун тавь*) төгрөг, эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн 1,000,000,000 (*нэг тэрбум*) төгрөг буюу нийт 2,012,683,150 (*хоёр тэрбум арван хоёр сая зургаан зуун наян гурван мянга нэг зуун тавь*) төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан.

“Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкийг сонгон шалгаруулах, хөнгөлөлтэй зээл олгох, эргэн төлөх, хяналт тавих” журмын 6.2-д заасны дагуу Кино урлагийн зөвлөл нь сонгон шалгаруулалтаас шалгарсан 10 төсөл, арга хэмжээний төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй КУДС-ийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэх гэрээг 2024.12.18 – 2024.12.24-ны хооронд байгуулж, Кино урлагийн зөвлөлийн даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/88 “Зардал гаргах тушаал”-аар эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилтийн төсөл тус бүрд олговол зохих санхүүжилтийн урьдчилгаа 80 хувь болох **810,146,520 (найман зуун арван сая нэг зуун дөчин зургаан мянга таван зуун хорин)** төгрөг, 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/92 “Зардал гаргах тушаал”-аар эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээл олгор санхүүжилтээр **1,000,000,000 (нэг тэрбум)** төгрөг олгосон.

**Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлсэн төслийн мэдээлэл**

**ЭРГЭН ТӨЛӨХ НӨХЦӨЛГҮЙ ОЛГОХ САНХҮҮЖИЛТ**

№	Төслийн нэр, төрөл	Төслийг хэрэгжүүлэгч байгууллага иргэн	КУЗ-ийн санал дүгнэлт, санхүүжүүлэх хэмжээ (төгрөгөөр)	Санхүүжилт авсан төслийн үе шат
<b>1.1. Кино бүтээх төсөл</b>				
1.1.1	“Механизм” уран сайхны кино	“Джон Шипскин” ХХК	175,730,250.00	- Кино зураг авалт, дуу, дүрсний найруулгын үе шат
1.1.2	“Санамсар” уран сайхны кино	Лхагважав овогтой БАТ-АМГАЛАН /ЧЕ83052276/	262,952,900.00	- Кино зураг авалт, дуу, дүрсний эвлүүлгийн найруулга - Олон нийтэд хүргэх бэлтгэл ажил
1.1.3	“Бурантаг” баримтат кино	“Боловсрол соёл эрх зүйн дээд сургууль” Холбоо /БСБ/	50,000,000.00	- Кино хөгжүүлэлт
1.1.4	“Сэтгэлийн зураг” уран сайхны кино	“Гайхамшигт хүн продакшн” ХХК	100,000,000.0	- Кино зураг авалт, дуу, дүрсний эвлүүлгийн найруулга - Олон нийтэд хүргэх бэлтгэл ажил
1.1.5	“Хайхрал” богино хэмжээний кино	“Лотус пикчерс” ХХК	20,000,000.0	- Кино зураг авалт, дуу, дүрсний найруулга
<b>1.2. Олон Улсын кино наадам зохион байгуулах</b>				
1.2.1	“Веб драма виртуал фестиваль” Олон Улсын кино наадам зохион байгуулах	Даваасамбуу ЦЭНГЭЛ /ХЛ83102206/	20,000,000.0	- Кино наадмын бэлтгэл ажлыг хангах - Кино наадам зохион байгуулах
1.2.2	“Улаанбаатар” Олон Улсын кино	“Монголын урлагийн зөвлөл	100,000,000.0	- Кино наадмын бэлтгэл ажлыг хангах

	наадам зохион байгуулах Веб драма виртуал фестиваль” Олон Улсын кино наадам зохион байгуулах	төв” Холбоо /НҮТББ/		- Олон улсын кино наадам зохион байгуулах
1.2.3	“Хархорум 2025” Олон Улсын кино наадам зохион байгуулах	“Киноны гүүр хөгжлийн холбоо” Холбоо /НҮТББ/	184,000,000.0	- Кино наадмын бэлтгэл ажлыг хангах - Олон улсын кино наадам зохион байгуулах
<b>1.3. Кино урлагийн уран бүтээлч ажилтныг хөгжүүлэх сургалт</b>				
1.3.1	“Кино нүүдэл сургалт” кино зохиол, кино төслийн сургалт	“Киноны нүүдэл” Холбоо /НҮТББ/	100,000,000.0	- Сургалтын бэлтгэл ажлыг хангах - Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах
<b>НИЙТ</b>			<b>1,012,683,150.0</b>	

ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ САНХҮҮЖИЛТ

<b>2.1. Кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэх</b>				
2.1.1	“Дарьганга” кино театр	“Шидэт-Ертөнц” ХХК	1,000,000,000.0	- Кино үйлдвэрлэлд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн техник технологи, программ хангамж, инновац нэвтрүүлэх
<b>НИЙТ</b>			<b>1,000,000,000.0</b>	